



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 02 дугаар сарын 29

Дугаар 18/04

Баян-Өндөр сум

“Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг
бууруулах” хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:


1.Эрдэнэт үйлдвэрийн хаягдлын санд хуримтлагдсан технологийн хаягдал булингаас үүсэлтэй цагаан тоосны дэгдэлтийг бууруулах, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, тухайн бүсийн экологид учруулах нөлөөллийг бууруулах зорилгоор “Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах” хөтөлбөрийг нэгдүгээр, “Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар, “Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах” хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн IV улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг аймгийн Засаг дарга, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын захирал нарт тус тус даалгасугай.

3.“Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хоёрдугаар үе шатны төлөвлөгөө, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг 2027 оны IV улиралд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Түмэнжаргал), “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ (Г.Ёндон)-д тус тус үүрэг болгосугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ

C:\My documents\togtool

6179100015

**ЦАГААН ТООСНЫ ДЭГДЭЛТ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ
БУУРУУЛАХ ХӨТӨЛБӨР
НЭГ.ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ**

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Баяжуулах үйлдвэрийн хаягдал нь олон төрлийн эрдэс, химийн найрлагатай, буталсан хад чулуулаг, бага үнэ цэнтэй үлдэгдэл ашигт малтмалаас тогтсон элс, ашигт малтмал олборлоход ашигласан бодис, ус зэргээс тогтсон Техногенийн орд юм.

Хаягдлын аж ахуй нь Баяжуулах үйлдвэрээс баруун хойд зүгт 4.5 км зайд Зуны голын хөндийд байрлана. Баяжуулах үйлдвэр анх ашиглалтад орсон өдрөөс Хаягдлын аж ахуй үйл ажиллагаагаа явуулж ирсэн бөгөөд тус хэсэг нь баяжуулах процессоос гарч буй хүдрийн 98 хувиас дээш хаягдал (булинг)-ыг баяжуулах үйлдвэрээс хаягдлын далан хүртэл усан тээвэрлэлт хийж, хаягдлын санд хураах, хадгалах үйл ажиллагаа явуулж ирсэн.

ХОЁР.ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ

2.1.Физик, химийн шинж чанар, бүтэц найрлага:

Цагаан тоосны физик шинж чанарыг авч үзвэл олон жил болсон цагаан тоос нь хуурай үедээ цайвар цагаан өнгийн, сийрэг, үнэргүй, элсэн, элсэнцэр бүрэлдэхүүнтэй, урвалын орчин сулавтар шүлтлэг шинжтэй рН 7,35-7,45 байхад шинэхэн хаягдал нь хөхөвтөр туяатай, саарал өнгийн, зууралдсан, нягтавттар, хурц, эхүүн үнэртэй, урвалын орчин хэт шүлтлэг шинжтэй рН 7,5-11,0 байна. Хуурай болон нойтон цагаан тоосны урвалын орчин ялгаатай байгаа нь технологийн үйл ажиллагаа болон олон жил хуримтлагдсан цагаан тоос нь цас бороо, голын усаар угаагдсантай холбоотой.

Хаягдлын санд хуримлагдаж буй хаягдлын ерөнхий химийн найрлагын хувьд:

SiO ₂ %	Al ₂ O ₃ %	Fe ₂ O ₃ %	CaO %	MgO %	Na ₂ O %	K ₂ O %	P ₂ O ₅ %
68.82	15.21	3.16	1.37	0.87	2.83	3.4	0.196

F %	As %	Cr %	Cu %	Mo %	Zn %
<0.05	0.0012	0.0025	0.030	0.0065	0.0112

(Геологийн төв лаборатори)

- Цахиурын исэл (SiO₂) – 68.82%
- Хөнгөн цагааны исэл (Al₂O₃) – 15.21%
- Төмрийн исэл (Fe₂O₃) – 3.16%
- Кальцийн исэл (CaO) – 1.37%
- Манганы исэл (MgO) – 0,875
- Натрийн исэл (Na₂O) – 2.83%
- Калийн исэл (K₂O) – 3.4
- Фосфорын исэл (P₂O₅) – 0.196
- Фтор (F) - <0.05%
- Хөнгөн цагаан (As) – 0.0012%
- Хром (Cr) – 0.0025%
- Cu (Зэс) – 0,003%
- Молебдин (Mo) – 0.0065%
- Цайр (Zn) – 0.0112%

2.2. Цагаан тоосны эх үүсвэр, тархалт.

Эрдэнэт үйлдвэрийн хаягдлын санд хуримтлагдсан технологийн хаягдал булинга, цагаан элснээс салхинд дэгдэн үүсдэг цагаан тоосны сөрөг үр дагавар нь өнөөдөр тус үйлдвэрийн бүсийн хот суурины хүн амын эрүүл мэнд, газар тариалан, мал аж ахуй төдийгүй тухайн нутгийн ландшафтын экосистемийн хувьд тулгамдсан асуудал болоод байна.

Цагаан тоос нь үйлдвэрийн үндсэн хэсэг болох Баяжуулах үйлдвэрийн байгууламжаас гарах үйлдвэрийн технологийн хаягдлын булинга хүлээн авдаг Хаягдлын аж ахуйн сангаас гардаг. Энэхүү хаягдлын сан нь 1978 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж, энэ хугацаанд нэмэгдсээр одоогийн байдлаар жилд дунджаар 27,0-33.0 сая тонн цагаан элс хуримтлуулсаар иржээ. 2023 оны эхний байдлаар тус үйлдвэрийн хаягдлын санд нийтдээ 969.1 сая тонн элс хуримтлагдаад байна. Хаягдлын сан нь нийт 2197.7 га талбайг эзлэн оршиж байгаагаас 1364.8 га талбай нь цагаан тоос дэгдэх голомт болж байна.

Тархалтын хувьд салхины урсгалын зонхилох чиглэлээс хамаарч Эрдэнэт үйлдвэрийн хаягдлын сангийн эргэн тойронд болон Хангал голын хөндий дагуу Жаргалант сум хүртэлх 30 орчим км² нутагт жилд дунжаар 4500 гаруй тонн цагаан тоос тархаж байгааг судалгаагаар тогтоосон байдаг.

“Эрдэнэт хотын хүрээлэн буй орчны мониторинг судалгааны тайлан 2015”-д туссанаар Эрдэнэт үйлдвэрийн хаягдлын аж ахуйн цагаан тоосны тархалтын чиглэл нь сар бүрийн салхины зонхилох урсгалыг дагаад харилцан адилгүй ба өвлийн улирал буюу 11, 12, 1 дүгээр саруудад тоосонцрын тархалт нь харьцангуй тогтворгүй боловч зүүн болон баруун өмнөд зүг рүү, хаврын сарууд буюу 2, 3, 4 дүгээр саруудад салхины хурд 18-20м/с, хүчтэй шуургатай үед 23м/с-ээс давж салхилах бөгөөд цагаан тоосны тархах чиглэлийн хувьд тогтворгүй, бүх тал руу тархалттай байна.

Хавар, намрын улирал буюу 4, 5, 9, 10 дугаар саруудад цагаан тоосны тархалтын чиглэлийг харвал зүүн болон өмнөд, баруун өмнөд зүг рүү чиглэсэн тархалттай байдаг байна.

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь цагаан тоосны дэгдэлтийг багасгах зорилгоор багагүй хэмжээний хөрөнгө зарцуулан усалгааны болон бусад арга хэмжээг төлөвлөгөөтэйгөөр явуулж, тодорхой үр дүнд хүрч байгаа боловч бүрэн дарж чадахгүй байна.

2.3.Цагаан тоосны нөлөөллийг судлах хэрэгцээ шаардлага

Хаягдлын сан нь их хэмжээний газрыг эзлэн байрлаж, түүнээс үүсэх тоос нь салхины нөлөөгөөр агаарт дэгдэж, тухайн орчны хөрс, ус, агаарыг бохирдуулж, байгаль-экологид сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа эсэхийг зайлшгүй судлах шаардлагатай байна.


2006-2019 онуудад тус нутгийн хүн амын дунд эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулсан боловч тодорхой үр дүн гараагүй тул эрүүл мэндийн үзлэгийг илүү нарийвчилсан түвшинд зохион байгуулах шаардлага тулгарч байна.

ГУРАВ.ХАЯГДЛЫН САН, ЦАГААН ТООСНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

3.1.Хаягдлын аж ахуйн тоон үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2022 оны 1-р сар	2023 оны 1-р сар
1	Хаягдлын сангийн нийт эзлэх талбай	га	2128.16	2197.7
2	Далангуудын эзлэх талбай	га	160.9	161.2
3	Хаягдал элсний эзлэх талбай	га	1482.4	1364.8
4	15-р далангийн өндрийн түвшин	м	1305	1305
5	Хаягдал элсний түвшин (Хамгийн их) (Дундаж)	м	1303.79 1296.9	1305 1297.5
6	Далангаас нуур хүртэлх зай	м	2500	2465
7	Нуурын усны түвшингийн өсөлт (1 жилийн хугацаанд)	м	1.56	1.08
8	2021, 2022 онд хаягдсан элсний хэмжээ	сая тн	32.067	33.023
9	Хаягдлын санд хуримтлагдсан нийт элсний хэмжээ	сая тн	936.102	969.125


Хуримтлагдсан элсний хэмжээ сая/тонн




3.2.Хаягдлын сангийн өнөөгийн байдал



3.3.Цагаан тоосны дэгдэлтийн дүн, мэдээ /2022он, 2023 он/



2022 онд нийт 27 удаа их хэмжээгээр цагаан тоос дэгдсэн бөгөөд салхины хурд хамгийн багадаа 8 м/с, хамгийн ихдээ 28 м/с хурдтай байсан байна.



2023 оны 10 дугаар сарын байдлаар цагаан тоос нийт 30 удаа их хэмжээгээр дэгдсэн бөгөөд салхины хурд хамгийн багадаа 9м/с, хамгийн ихдээ 27м/с хурдтай байсан байна.

Дээр өгүүлсэн нөхцөл байдал болон Эрдэнэт үйлдвэрийн технологийн хаягдлаас гарч байгаа цагаан тоосны байгаль орчин, хүн, малын эрүүл мэнд, экологийн сөрөг нөлөөллийн цар хүрээ, үр дагаврыг үнэлэхэд, энэ талаар бодлогын түвшний арга хэмжээ авах нь зайлшгүй шаардлагатай байна.

ДӨРӨВ.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

4.1.Эрдэнэт үйлдвэрийн хаягдлын санд хуримтлагдсан технологийн хаягдал булингаас үүсэлтэй цагаан тоосны дэгдэлтийг бууруулах, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, тухайн бүсийн экологид учруулах нөлөөллийг бууруулахад энэхүү хөтөлбөрийн ЗОРИЛГО оршино.

4.2.Хөтөлбөрийн зорилгод хүрэхийн тулд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ.

4.2.1.Цагаан тоосны тархалтад нөлөөллийн үнэлгээ, судалгаа, мониторинг хийх.

4.2.2.Хаягдлын аж ахуйн цагаан тоосны дэгдэлтийг бууруулах технологийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

4.2.3.Цагаан тоосны тархалтын бүсэд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

4.2.4.Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах.

4.2.5.Иргэдийг мэдээллээр хангах ажлыг тогтмол зохион байгуулах.

ТАВ. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА, ҮЕ ШАТ

Цагаан тоосны дэгдэлт, сөрөг нөлөөллийг бууруулах хөтөлбөрийг 2 үе шаттайгаар 2031 он хүртэл хугацаанд хэрэгжүүлнэ.

- ✓ 2024-2027 он хүртэл хугацаанд хэрэгжүүлнэ.
- ✓ 2028-2031 он хүртэл хугацаанд хэрэгжүүлнэ.

ЗУРГАА.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТУУДЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

6.1.Нэгдүгээр зорилт: Цагаан тоосны тархалтад нөлөөллийн үнэлгээ, судалгаа, мониторинг хийх.

6.1.1.Байгаль орчны хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийлгэх.

6.1.2.Цагаан тоосны дэгдэлтийн тоо, зүг чиг, хэмжээ, үргэлжилсэн цаг хугацаанд тогтмол мониторинг хийх.

6.1.3.Агаар, ус, хөрсний чанарын хяналтыг үйлдвэрийн бүс, хаягдлын сан, нөлөөллийн бүсүүдэд хийж, тогтмол дээж авч хяналт тавих.

6.1.4.Уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас газрын доорх усанд хяналт тавих зорилгоор усны мониторингийн цооногоос дээж авч тогтмол ажиглалт хийх.

6.2.Хоёрдугаар зорилт: Хаягдлын аж ахуйн цагаан тоосны дэгдэлтийг бууруулах технологийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

6.2.1.Хуурайшилттай талбайг багасгах зорилгоор хаягдал булингаар болон усаар норгох.

6.2.2.Тусгай зориулалтын техник, төхөөрөмж ашиглан дарагч урвалж цацаж тоосны дэгдэлт бууруулах.

6.2.3.Хуурайшилттай талбайг бороожуулах зорилгоор Хаягдлын аж ахуйг тойруулан усан хангамжийн систем суурилуулах.

6.2.4.Шинэ хаягдлын аж ахуй барих ажлыг эрчимжүүлж, газрын байршлын асуудал шийдвэрлэх, шинэ хаягдлын аж ахуйг байгуулах.

6.3.Гуравдугаар зорилт: Цагаан тоосны тархалтын бүсэд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх

6.3.1.Баяжуулах үйлдвэрийн Хаягдлын аж ахуйг хамгаалалтын ойн зурвас, төгөл байгуулах.

6.3.2.Хангал голын дагуу бургасан плантаци үүсгэх.

6.3.3.Говил багийн иргэдийг оролцуулан мод тарих, ногоон байгууламж хийх, иргэдээс гарсан санал санаачилгыг дэмжих.

6.3.4.Жаргалант сумын иргэдийн тариалсан хүнсний ногооны борлуулалтад дэмжлэг үзүүлэх.

6.4.Дөрөвдүгээр зорилт: Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах.

6.4.1.Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний тайланг хүлээн авах.

6.4.2.Иргэдийн эрүүл мэндийн үзлэг, шинжилгээг жил бүр зохион байгуулах.

6.4.3.Нөлөөллийн бүсэд байрлах сургууль, цэцэрлэгийн дотоод орчны агаарын чанарыг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

6.5.Тавдугаар зорилт: Иргэдийг мэдээллээр хангах ажлыг тогтмол зохион байгуулах.

6.5.1.Үйлдвэрийн үйл ажиллагаа, цагаан тоосны талаар иргэдийг бодит мэдээллээр хангах ажлыг бүх хэлбэрээр (цахим, биечлэн, газар дээр нь танилцуулах) зохион байгуулах.

6.5.2.Хөтөлбөрийн хэрэгжилтийг Орон нутгийн удирдлага, Багийн Иргэдийн нийтийн хурал, иргэний нийгмийн байгууллагуудад жил бүр тайлагнах, мэдээллээр хангах.

6.5.3.Нөлөөллийн бүсийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад болон иргэдэд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ногоон хөгжлийн төслийн нэгжийн ойн генетик нөөцийн “Эрдэнэт” төв, “Хөрсний инновац, технологи”-ийн төвтэй хамтран байгаль орчны чиглэлээр сургалт зохион байгуулах.

ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН

7.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэхдээ 2023 оны жилийн эцсийн үзүүлэлтийг суурь болгон явц болон үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

№	Зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин /2023 он/	Зорилтот түвшин /2027он/	Зорилтот түвшин /2031он/
1.	Зорилт 1. Цагаан тоосны тархалтад нөлөөллийн үнэлгээ, судалгаа, мониторинг хийх.	Үнэлгээ, мониторинг тоо, төрөл, давтамж, шинжилгээний дүн	Тоо/ш	-Үнэлгээ- 0, - мониторингийн үзүүлэлтийн төрөл- 6, давтамж-өдөр тутам	Үнэлгээ- 1, мониторингийн үзүүлэлтийн төрөл- 6, давтамж-өдөр тутам	Үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн дагуу ажлыг гүйцэтгэх, мониторингийн үзүүлэлтийн төрөл- 6, давтамж-өдөр тутам
2.	Зорилт 2. Хаягдлын аж ахуйн цагаан тоосны дэгдэлтийг бууруулах технологийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх.	Хаягдлын аж ахуйн тоос идэвхтэй дэгддэг хуурайшилт тай талбайгаас тоос дарсан хувь	Хувь	80%	85%	90%
		Шинэ хаягдлын аж ахуйг байгуулах	хувь	-	60%	90%
3.	Зорилт 3. Цагаан тоосны тархалтын бүсэд үзүүлэх нөлөөллийг	Шинээр байгуулсан ногоон байгуулам-	га	ХАА-д-34.6 га Хангал голд- 1.4 га	ХАА-га Хангал голд- га	ХАА-74.6 га Хангал голд-61.4 га

	бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх	жийн талбай, Тоо хэмжээ, Ургалтын хувь	ширхэг хувь	2100000 75%	2312000 75%	62166000 75%
4.	Зорилт 4. Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах.	Хамрагдсан иргэдийн тоо	тоо	488 (2019 онд үзлэгт хамрагдсан иргэн)	2024 оны эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ болон ажлын хэсгийн дүгнэлтэд тулгуурлан цаашид зохион байгуулах асуудлыг шийдвэрлэнэ	-
5	Зорилт 5. Иргэдийг мэдээллээр хангах ажлыг тогтмол зохион байгуулах.	Иргэдийн тоо	тоо	500 (нөлөөллийн бүсийн)	2000 (нөлөөллийн бүсийн)	4000 (нөлөөллийн бүсийн)

НАЙМ.УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТ

8.1.Хөтөлбөрийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь аймаг, сумдын ЗДТГ, бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

8.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ санхүүжүүлнэ.

ЕС.ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

9.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, “Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ”-тай хамтран гүйцэтгэж дүгнэлт, зөвлөмж бүхий тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргын зөвлөлд хүргүүлнэ.

9.2.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх мэдээ, мэдээллийг аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ хамтран олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ.



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн Ээлжит XVIII хуралдааны 18/04 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт

ЦАГААН ТООСНЫ ДЭГДЭЛТ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХӨТӨЛБӨРИЙГ 2024-2027 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ, 2024-2028 (сая.төг)	Суурь түвшин 2023 он	Зорилтот түвшин, үр дүн, төсөв (сая.төг)												Хэрэгжүүлэх байгууллага	
							2024 он			2025 он			2026 он			2027 он			Үндсэн	Хамтрагч
							Хүрэх үр дүн	Төсөв, сая.төг	Хүрэх үр дүн	Төсөв, сая.төг	Хүрэх үр дүн	Төсөв, сая.төг	Хүрэх үр дүн	Төсөв, сая.төг	Хүрэх үр дүн	Төсөв, сая.төг	Хүрэх үр дүн	Төсөв, сая.төг		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17				
Зорилго: Эрдэнэт үйлдвэрийн хаягдлын санд хуримтлагдсан технологийн хаягдал булингаас үүсэлтэй цагаан тоосны дэгдэлтийг бууруулах, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, тухайн бүсийн экологид учруулах нөлөөллийг бууруулахад энэхүү хөтөлбөрийн ЗОРИЛГО оршино.																				
Зорилт 1. Цагаан тоосны тархалтад нөлөөллийн үнэлгээ, судалгаа, мониторинг хийх.	1	Байгаль орчны хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийлгэх.	2024-2025	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	1300,0	-	-	300,0	-	1000,0	-	-	-	-	-	-	БОАЖЯ, ОУБ Аймгийн ЗДТГ			
	2	Цагаан тоосны дэгдэлтийн тоо, зүг чиг, хэмжээ, үргэлжилсэн цаг хугацаанд тогтмол мониторинг хийх	2024-2027	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	-	30 удаа	30 удаа	30 удаа	27 удаа	-	25 удаа	-	20 удаа	-	-	-	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ			
	3	Агаар, ус, хөрсний чанарын хяналтыг үйлдвэрийн бүс, хаягдлын сан, нөлөөллийн бүсүүдэд хийж, тогтмол дээж авч хяналт тавих	2024-2027	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	-	Агаар 4 удаа Ус 4 удаа Хөрс 1 удаа	Агаар 4 удаа	4 удаа	4 удаа	4 удаа	4 удаа	4 удаа	4 удаа	4 удаа	4 удаа	4 удаа	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ			

2	3	4	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
	Шинэ хаягдлын аж ахуй барих ажлыг эрчимжүүлж, газрын байршлын асуудал шийдвэрлэх, шинэ хаягдлын аж ахуйг байгуулах.	2024-2027	-	Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах сана-лын талаар аймгийн ИТХ-ын тогтоол гаргана.	-	Баяжуулах үйлдвэрийн төлөвлөгөөнд тусгаснаар	Баяжуулах үйлдвэрийн төлөвлөгөөнд тусгаснаар	Баяжуулах үйлдвэрийн төлөвлөгөөнд тусгаснаар	-	Баяжуулах үйлдвэрийн төлөвлөгөөнд тусгаснаар	-	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	ЗГХЭГ БОАЖЯ, Аймгийн ЗДТГ
Зорилт 3. Цагаан тоосны тархалтын бүсэд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Баяжуулах үйлдвэрийн Хаягдлын аж ахуйн хэсэгт ойн зурвас, төгөл байгуулах	2024-2027	34.6 га 2,100,000 ширхэг	10 га 15,000 ширхэг	380.0	10 га 15,000 ширхэг	380.0	10 га 15,000 ширхэг	380.0	10 га 15,000 ширхэг	380.0	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	-
	Хангал голын дагуу бургасан плантаци үүсгэх.	2024-2027	1.4 га 6000 ширхэг	10 га 20,000 ширхэг	350.0	10 га 20,000 ширхэг	350.0	20 га 40,000 ширхэг	400.0	20 га 40,000 ширхэг	400.0	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	-
	Говил багийн иргэдийг оролцуулан мод тарих, ногоон байгууламж, иргэдээс гарсан санал санаачилгыг дэмжих.	2024-2027	0 га 0 ширхэг	0.5 га 1500 ширхэг	15.0	0.5 га 1500 ширхэг	0.5 га 1500 ширхэг	15.0	0.5 га 1500 ширхэг	15.0	0.5 га 1500 ширхэг	15.0	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ
4	Жаргалант сумын аж ахуй нэгж, иргэдийн тариалсан хүнсний ногооны борлуулалтад дэмжлэг үзүүлэх.	2024-2027	4	4	-	4	-	4	-	4	-	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	Жаргалант сумын ЗДТГ

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
Зорилт 4. Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах	1	Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний тайланг хүлээн авах.	2024	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	20.0	20.0	Тайлан	20.0	-	-	-	-	-	-	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	Аймгийн ЗДТГ, Эрүүл мэндийн газар
	2	Иргэдийн эрүүл мэндийн үзлэг, шинжилгээг жил бүр зохион байгуулах.	2024-2027	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	3000.0	488 иргэд	2500 иргэд	750.0	2500 иргэд	750.0	2500 иргэд	750.0	2500 иргэд	750.0	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	ЭМГ, БОЭТ аймгийн ЗДТГ, Сумдын ЗДТГ
	3	Нөлөөллийн бүс (Говил баг, Вокзалын хэсэг, Жаргалант сум)-д байрлах сургууль, цэцэрлэгийн дотоод орчны агаарын чанарыг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх.	2024-2027	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	160.0	35.0	194м ²	40.0	194м ²	40.0	40.0	194м ²	40.0	194м ²	40.0	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ
Зорилт 5. Иргэдийг мэдээллээр хангах ажлыг тогтмол зохион байгуулах.	1	Үйлдвэрийн үйл ажиллагаа, цагаан тоосны талаар иргэдийг бодит мэдээллээр хангах ажлыг бүх хэлбэрээр (цахим, биечлэн, газар дээр нь танилцуулах) зохион байгуулах	2024-2027	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	Бизнес төлөвлөгөөнд тусгаснаар	8 удаа	8 удаа	-	8 удаа	-	8 удаа	-	8 удаа	-	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	Аймгийн ЗДТГ, БОАЖГ, ЭМГ, Сумдын ЗДТГ
	2	Хөтөлбөрийн хэрэгжилтийг Орон нутгийн удирдлага, Багийн ИНХ, Иргэний нийгмийн байгууллагуудад жил бүр тайлагнах, мэдээллээр хангах.	2024-2027	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	-	6 удаа	6 удаа	-	10 удаа	-	10 удаа	-	10 удаа	-	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	Аймгийн ЗДТГ, БОАЖГ, ЭМГ, Сумдын ЗДТГ

2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
	Нөлөөллийн бүсийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад болон иргэдэд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-Ногоон хөгжил төслийн нэгжийн Ойн генетик нөөцийн "Эрдэнэт" төв, "Хөрсний инновац, технологийн төв" -д байгаль орчны чиглэлээр сургалт зохион байгуулах.	2024-2027	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	-	0	60	-	120	-	150	-	180	-	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	Аймгийн ЗДТГ, БОАЖГ, ЭМГ, Сумдын ЗДТГ

-- 000 --



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн Ээлжит XVIII хуралдааны ... дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт

“ЦАГААН ТООСНЫ ДЭГДЭЛТ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ” ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН НЭГДҮГЭЭР ҮЕ ШАТНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Зорилтот түвшин				Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага	
			2023 он	2024 он	2025 он	2026 он				2027 он
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

Зорилго: Эрдэнэт үйлдвэрийн хаягдлын санд хуримтлагдсан технологийн хаягдал булингаас үүсэлтэй цагаан тоосны дэгдэлтийг бууруулах, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, тухайн бүсийн экологид учруулж буй сөрөг үр дагаврыг бууруулахад оршино.

Зорилт 1. Цагаан тоосны тархалтад нөлөөллийн үнэлгээ, судалгаа мониторинг хийнэ.

1	Шинээр Үнэлгээ, хийлгэсэн	ш	0	0.5	1	-	1 иж бүрэн судалгааны ажлын тайлан	хагас, бүтэн жилээр	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ
2	Мониторинг үзүүлэлтийн төрөл, давтамж	Тоо хэмжээ	мониторингийн үзүүлэлтийн төрөл- 6, давтамж- өдөр тутам	мониторингийн үзүүлэлтийн төрөл- 6, давтамж- өдөр тутам	мониторингийн үзүүлэлтийн төрөл- 6, давтамж- өдөр тутам	мониторингийн үзүүлэлтийн төрөл- 6, давтамж- өдөр тутам	мониторингийн үзүүлэлтийн төрөл- 6, давтамж- өдөр тутам	Өдөр тутам	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ
3	Агаар, ус, хөрсний чанарын хяналтын шинжилгээний дүн	Тоо хэмжээ	9	9	9	9		хагас, бүтэн жилээр	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ
4	Усны мониторингийн цооногоос авсан дээжийн шинжилгээний дүн	Тоо хэмжээ	10	10	10	10	Дэгдэлтийн тоо	хагас, бүтэн жилээр	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ

Зорилт 2. Хаягдлын аж ахуйн цагаан тоосны дэгдэлтийг бууруулах технологийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

1	Тоос дарсан талбайн эзлэх хувь	хувь	80%	83%	85%	85%	2023 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ
---	--------------------------------	------	-----	-----	-----	-----	---	---------------------	------------------------

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
2	Шинэ хаягдлын аж ахуй барих ажлыг эрчимжүүлж, газрын байршлын асуудал шийдвэрлэх, суурь судалгааны ажлыг эхлүүлэх.	хувь	0	50%	70%	90%	100%	2023 оны суурь түвшингээс өссөн дүнгээр.	хагас, бүтэн жилээр	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ
Зорилт 3. Цагаан тоосны үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх										
1	Шинээр байгуулсан ногоон байгууламжийн талбай, тоо хэмжээ,	Га	34.6	10	10	10	10	2023 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ
		ширхэг	2.1сая	15000	15000	15000	15000	2023 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ
2	Хангал голын дагуу бургасан плантаци үүсгэсэн талбай, тоо хэмжээ	га	1.4	10	10	20	20	2023 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ
		ширхэг	6000	20000	20000	40000	40000	2023 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ
3	Говил багийн иргэдийг оролцуулан мод тарих, ногоон байгууламжийн талбай, тоо хэмжээ	га	0	0.5	0.5	0.5	0.5	2023 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ
		ширхэг	0	1500	1500	1500	1500	2023 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ
4	Жаргалант сумын иргэдийн борлуулалтад дэмжлэг үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийн тоо	иргэн, аж ахуйн нэгжийн тоо	4	4	4	4	4	2023 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ

1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Зорилт 4. Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах										
1	Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний тайлан	ш	0	0.5	1	-	-	-	хагас, бүтэн жилээр	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, Аймгийн ЗДТГ
2	Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан иргэдийн тоо	Иргэдийн тоо	0	2500	2500	2500	2500	2023 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, Аймаг, сумдын ЗДТГ, ЭМГ
3	Шүүлтүүр суурилуулсан цацарлаг сургуулийн цонхны салхивчны хэмжээ	М²	194	200	210	220	230	2023 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ
Зорилт 5. Иргэдийг бодит мэдээллээр хангах ажлыг тогтмол зохион байгуулах.										
1	Мэдээлэл хийсэн давтамжийн тоо	удаа	8	8	8	8	8	2023 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ
2	Мэдээлэл өгсөн давтамжийн тоо	удаа	6	6	10	10	10	2023 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ
3	Сургалтад хамруулж, чадавхжуулсан сурагчид, иргэдийн тоо	Тоо	0	60	120	150	180	2023 оны суурь түвшингээс өссөн дүнгээр	хагас, бүтэн жилээр	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, сумдын ЗДТГ, БОАЖГ